



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/41/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Ц.Аззаяа
Утас: 99125777
цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.5.3 Нэмэлт төсөв	12
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
2021 оны сүүлээр шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа байгууллага тул өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт байхгүй болно.	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Залруулсан алдаа.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГА М.ПҮРЭВХҮҮ ТАНАА

**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.24 № 02/83
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Соёл, Урлагийн газар нь анх аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/405 дугаар захирамжаар байгуулагдан дарга-1, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга-1, Соёлын хэлтсийн дарга-1, Хөрөнгө оруулалт, төсвийн ахлах мэргэжилтэн-1, Бодлого, төлөвлөлт, тайлагналт цахимжилт хариуцсан ахлах мэргэжилтэн -1, мэргэжилтэн-3, нягтлан бодогч -1, нярав, бичиг хэрэг-1, үйлчлэгч-1 гэсэн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 46 ажил төлөвлөж гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 96.5 %-ийн биелэлттэй хэрэгжсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	5,405,639.0
33	АВЛАГА	-	18,835.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	18,835.0
35	БАРАА МАТЕРИАЛ	-	5,386,804.0
354	Хангамжийн материал	-	5,386,804.0
35440	Түлш, шатах тослох материал	-	4,400,004.0
35470	Бусад хангамжийн материал	-	986,800.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	44,608,433.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	44,608,433.9
392	Биет хөрөнгө	-	43,183,433.9
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	38,331,043.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,399,614.7)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	9,034,758.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(782,752.4)
393	Биет бус хөрөнгө	-	1,425,000.0
39301	Програм хангамж	-	1,500,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(75,000.0)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	50,014,072.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	92,454.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	92,454.0
413	Өглөг	-	92,454.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	92,454.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	49,921,618.9
51	Засгийн газрын хувь оролцоо	-	49,921,618.9
512	Хуримтлагдсан үр дүн	-	49,921,618.9
51220	Тайлант үеийн үр дүн	-	49,921,618.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	50,014,072.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	452,335,599.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	10,944,025.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	10,944,025.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	10,295,201.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	10,295,201.0
120009	Бусад орлого	-	648,824.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	441,391,574.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	212,628,700.0

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	212,628,700.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	224,847,900.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	63,638,900.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	94,709,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	66,500,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	5,695,600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	5,695,600.0
1330	Төсвийн захирагчдаас	-	(1,780,626.0)
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	(1,780,626.0)
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	402,465,058.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	402,465,058.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	312,815,654.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	119,621,494.0
210101	Үндсэн цалин	-	84,607,086.0
210102	Нэмэгдэл	-	14,970,014.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,811,500.0
210104	Урамшуулал	-	6,232,894.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	14,952,973.2
210201	Тэтгэврийн даатгал	-	10,167,831.4
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,196,496.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	956,971.9
210204	Ажилгүйдлийн даатгал	-	239,243.1
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,392,429.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	1,300,000.0
210302	Түлш, халаалт	-	100,000.0
210304	Байрны түрээс	-	1,200,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	22,512,571.0
210401	Бичиг хэрэг	-	10,216,870.0
210402	Тээвэр, шатахуун	-	6,176,396.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	642,200.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	53,600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	5,423,505.0
2107	Томилолт, зочны зардал	-	2,000,000.0
210702	Дотоод албан томилолт	-	2,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,531,424.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,531,424.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	148,897,192.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	144,639,825.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	4,257,367.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	89,649,403.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	29,100,000.0

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	29,100,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	60,549,403.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	60,549,403.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	=	49,870,540.9
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	=	49,870,540.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	=	442,040,398.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	648,824.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	648,824.0
120009	Бусад орлого	-	648,824.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	441,391,574.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	212,628,700.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	212,628,700.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	224,847,900.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	63,638,900.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	94,709,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	66,500,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	5,695,600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	5,695,600.0
1330	Төсвийн захирагчдаас	-	(1,780,626.0)
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	(1,780,626.0)
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	=	427,091,476.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	427,091,476.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	337,442,072.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	119,747,583.1
210101	Үндсэн цалин	-	84,733,175.1
210102	Нэмэгдэл	-	14,970,014.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,811,500.0
210104	Урамшуулал	-	6,232,894.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	14,753,265.0
210201	Тэтгэврийн даатгал	-	10,103,142.3
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,198,343.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	958,674.5
210204	Ажилгүйдлийн даатгал	-	239,668.7
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,253,436.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	2,075,900.0
210302	Түлш, халаалт	-	875,900.0
210304	Байрны түрээс	-	1,200,000.0

2104	Хангамж, бараа материалын зардал	-	9,050,500.0
210401	Бичиг хэрэг	-	1,374,700.0
210402	Тээвэр, шатахуун	-	6,516,500.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	849,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	78,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	231,800.0
2107	Томилолт, зочны зардал	-	2,000,000.0
210702	Дотоод албан томилолт	-	2,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	4,812,224.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,812,224.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	185,002,600.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	185,002,600.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	89,649,403.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	29,100,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	29,100,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	60,549,403.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	60,549,403.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>14,948,922.0</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	15,000,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	15,000,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	-	15,000,000.0
223001	Бусад хөрөнгө	-	383,800.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	14,616,200.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(15,000,000.0)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(51,078.0)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D08	Тайлант үеийн үр дүн	49,921,618.9	49,921,618.9
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49,921,618.9	49,921,618.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	216,543,674	155,994,270.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	216,543,674	155,994,270.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216,157,674	155,994,270.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,754,877	119,640,329.00
210101	Үндсэн цалин	104,516,777	84,625,921.00
210102	Нэмэгдэл	46,900,000	14,970,014.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,200,000	13,811,500.00
210104	Урамшуулал	7,138,100	6,232,894.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,719,297	14,809,441.15
210201	Тэтгэврийн даатгал	14,769,198	10,167,831.42
210202	Тэтгэмжийн даатгал	1,737,500	1,196,214.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,390,040	956,971.89
210204	Ажилгүйдлийн даатгал	347,460	239,243.05
210205	Эрүүл мэндийн даатгал	3,475,100	2,249,179.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,205,900	2,075,900.00
210301	Гэрэл, цахилгаан	65,900	-
210302	Түлш, халаалт	937,600	875,900.00
210303	Цэвэр, бохир ус	129,800	-
210304	Байрны түрээс	2,072,600	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,917,700	7,908,700.00
210401	Бичиг хэрэг	1,374,700	1,374,700.00
210402	Тээвэр, шатахуун	5,515,500	5,515,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	642,200	642,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,500	144,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,800	231,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,013,400	4,013,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,013,400	4,013,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,546,500	5,546,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,546,500	5,546,500.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	386,000	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	386,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	386,000	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	216,543,674.00	155,994,271.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	212,628,700.00	152,079,297.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	212,628,700.00	152,079,297.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,914,974.00	3,914,974.00
122005	Орон нутгийн төсвөөс	3,914,974.00	3,914,974.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	224,847,900.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	224,464,100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,364,100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	935,000.0
210402	Тээвэр, шатахуун	935,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,429,100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	194,429,100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,100,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,100,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,100,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	383,800.0
2200	Дотоод эх үүсвэрээр	383,800.0
223001	Бусад хөрөнгө	383,800.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	224,847,900.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	224,847,900.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	63,638,900.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	94,709,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,500,000.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Соёл урлагийн газар нь Соёлын өвийг өвлүүлэн түгээн дэлгэрүүлж, техник технологийн ололттой хослуулан соёл урлагаа хөгжүүлж хэл, соёл, түүхээрээ бахархан эх орноо хайрлах үзэл ухамсрыг төлөвшүүлж соёлын үнэ цэнийг нэмэгдүүлнэ гэж эрхэм зорилгоо тусгасан ба олон угсаатны өв соёлоор дамжуулан иргэд нийтэд соёлын дархлааг бий болгох алсын хараатай, чанартай үйлчилгээ үзүүлэх тасралтгүй хөгжих чадвартай мэргэшсэн мэргэжилтнүүдэд бий болгож сургалт, судалгаа, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана гэж тодорхойлжээ.

Ховд аймгийн Соёл урлагийн газар нь 2022 онд 11 орон тоотой ажиллаж, Аймгийн Хөгжимт драмын театр, Нийтийн номын сан, Аймгийн Музей, Сумдын Соёлын төв 16, нийт соёл урлагийн газрын салбарын 19 нэгжийг хамруулан тэдгээрийг захиргааны болон мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, зөвлөн тусалж ажиллажээ.

Соёлын сайдын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 1/1209 дугаар тушаалаар тус газрын бүтэц орон тоог 11 байхаар баталж, тайлант онд 11 албан хаагч, үйлчилгээний ажилтан ажилласан байна.

Дэлхий нийтийн "Тогтвортой хөгжлийн зорилтууд"-ын 4 дэх зорилго, Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024-ийг хэрэгжүүлэхийн тулд "Монгол хэл бичиг"-ийн дэд хөтөлбөр, Олон үндэстэн угсаатны өв соёл, урлаг дэд хөтөлбөр, Оюун түлхүүр дэд хөтөлбөр, Сонгодог урлаг III үндэсний дэд хөтөлбөрүүд багтдаг бөгөөд эдгээр хөтөлбөрүүдийг аймгийн хэмжээнд болон соёлын салбарын байгууллагуудад хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн дээд газраас ирүүлсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Үүнд: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаал, 2022 оны Аймгийн Засаг дарга болон Соёлын сайдтай байгуулсан 2022 оны 02-р сарын 18-ний өдрийн дугаар №-20 гэрээний биелэлттэй нийцүүлэн гаргасан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 46 ажил төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 100 % биелэлттэй -40, 70 % биелэлттэй -1, 50% биелэлттэй -1, 30% биелэлттэй-1, хэрэгжих хугацаа болоогүй 2 ажил, арга хэмжээ байна. Дундаж үнэлгээгээр гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 96,5 %-ийн биелэлттэй хэрэгжсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Соёлын өвийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Соёл урлагийн газрын даргын 2022.12.05-ны А/01 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо тооллого хийж, хяналт тавин ажилласан байна.

Соёлын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тайлант онд тус байгууллагад дотоод хяналт шинжилгээ хийсэн ба ажлын үзүүлэлтээрээ, хийж хэрэгжүүлсэн ажлаараа улсын хэмжээнд байр эзлүүлэхэд 2-р байранд шалгарсан амжилттай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл урлагийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Соёл урлагийн газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 50.0 сая төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		
Авлага	-	18.8	18.8
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	-	5,386.8	5,386.8
Нөөцийн бараа	-	-	-
Үндсэн хөрөнгө	-	44,608.4	44,608.4
Нийт хөрөнгө	-	50,014.0	50,014.0
Өр төлбөр	-	92.4	92.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	49,921.6	49,921.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	50,014.0	50,014.0

Дээрх хүснэгтээс харахад Соёл урлагийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 50,014.0 мянган төгрөг байна. Үүнд материаллаг нөлөө үзүүлж байгаа данс нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Бараа материал 26,597.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 21,210.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж 5,386.8 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Тайлант онд үндсэн хөрөнгө 48,865.8 мянган төгрөгөөр нэмэгдэж эцсийн үлдэгдэл 44,608.4 мянган төгрөгийн хөрөнгө байна.
- ✓ Авлага 18.8 мянган төгрөгийн ХХОАТ-ийн авлагатай байна.
- ✓ Өр төлбөр ба цэвэр хөрөнгийн дүн 50,014.0 мянган төгрөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Ховд аймаг дахь Соёл урлагийн газрын 2022 оны төсвийн төсөлд үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 233,149.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 216,543.7 сая төгрөгөөр Төсвийн төслийн саналаас 16.6 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлангийн хугацаанд тухайн байгууллага нь улсын төсвөөс 216,543.7 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 155,994.3 сая төгрөгийн зардал санхүүжүүлж, 60,549.4 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Соёлын яамнаас Соёлын сайдын А/212 тоот тушаалаар “Хүүхдэд зориулсан номын баяжилт” төслийн дагуу 12,750.0 мянган төгрөг, Соёлын яамнаас Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 25-ний 01/386 тоот тушаалаар “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд 6,600.0 мянган төгрөг, Соёлын сайдын А/249 тоот тушаал, Захчин түмний соёлын өвийн Тонжоо анхдугаар наадмыг зохион байгуулах 20,000.0 мянган төгрөг, Соёлын сайдын А/50 тоот тушаал Өв соёлын түүхэн дурсгалт газруудын улсын нэгдсэн тооллого хийх 10,000.0 мянган төгрөг, Аймгийн ЗД-ын А/611 захирамж, Цайны зам өв соёлын 3-р наадам зохион байгуулах 33,959.0 мянган төгрөг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын даргын Нүүдэлчин монгол 2022 наадамд шагналт байр эзэлсэн аймаг, нийслэл өвлөн уламжлагчдын шагнал,шилдэг отог урамшуулал 66,500.0 мянган төгрөг, Соёлын яамнаас Соёлын сайдын А/159 тоот тушаалаар “Мөнгөлөг шагшуурга” 2023 өвлийн наадмыг зохион байгуулах 20,000.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан ЗД-ын А/120 захирамжаар 1,690.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан ЗД-ын А/115 захирамжаар 1,545.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан “Хуучин байрны засварын санхүүжилт” 6,038.98 мянган төгрөг, Засаг даргын А/291 тоот захирамж, 4.8 хөтөлбөрийн соёл урлагийн үйл ажиллагааг чадавхжуулах 500.0 мянган төгрөг, Засаг даргын А/297 захирамж 500.0 мянган төгрөг, Засаг даргын А/422 захирамж Улсын баяр наадмын нээлтийг зохион байгуулах 11,340.0 мянган төгрөг, ЗД-ын А/461 захирамж 4.4 хөтөлбөр 947.0 мянган төгрөг, А/495 захирамж “Нүүдэлчин монгол” 2022 наадамд оролцоход бэлтгэл ажлыг хангах 13154.0 төгрөг, Соёлын яамнаас тоног төхөөрөмжийн санхүүжилт 15,000.0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас байрны засвар хийх санхүүжилт 323,92 мянган төгрөг, Аймгийн ЗДТГазраас Өвлөн

уламжлагчдадаа 3,183.0 сая төгрөг, нийт 225,030.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 224,805.3 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 225.6 мянган төгрөгийн хэмнэлт гарган төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Соёлын салбарын үйл ажиллагааг дэмжих зорилгоор 21 аймгийн 360 сумдын соёлын төвийн номын санд "Хүүхдэд зориулсан ном" хөтөлбөр болж 12,750.0 мянган төгрөг, Соёлын өвийн тооллого орон даяар болж 10,000.0 мянган төгрөг, Соёлын бүтээлч сар аяны хүрээнд 6,600.0 төгрөг, нийт 29,350.0 мянган төгрөгийг авч тус бүр авч үйл ажиллагааны зардалд бүрэн зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц.Аззаяа 2022 оны 02 дугаар сарын 17-ноос 02 дүгээр сарын 20-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар, аудитын менежер А.Цэцэгсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 402.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.4 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Соёл урлагийн газрын үйл ажиллагаанд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 9 дүгээр зүйлд заасан албан томилолт, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс,

нэмэгдэл, 15 дугаар зүйлийн 15.2 -ын зарим заалтууд хамаарахгүй байна. Мөн 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцастай холбоотой тус газраас зардал санхүүжүүлээгүй байна.

14 дүгээр зүйлд заасан зөрчлийн дэлгэрэнгүйг тайлангийн 5-д харуулав.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 119 мэдээлэл, хугацаа хоцроосон 40 мэдээлэл биелэлт 91 хувьтай байна. Үүнээс хөрөнгө оруулалт, тендер худалдан авах ажиллагааны мэдээлэл 39, төсөв гүйцэтгэлтэй холбоотой 73, бусад мэдээлэл 47 мэдээлэл шилэн дансанд оруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2021 оны сүүлээр шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа байгууллага тул өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс 17.9 сая төгрөгийн алдааг материаллаг хэмжээний алдаанд тооцохгүйгээр 1 зөвлөмж, 3.2 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудалд 1, нийт 2 зөвлөмж өглөө.

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдсэнгүй.

5.2 Зөвлөмж

5.4.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой

¹ Мэдээллийг тусгахгүй орхиадуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Илрүүлэлт: Микросити ХХК, Хоббизоон ХХК, Модон завь ХХК-аас 17.9 сая төгрөгийн компьютер, зургийн аппарат, тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрт худалдан авах хүсэлт байршуулахгүйгээр шууд худалдан авах гэрээ байгуулж төлбөрийг шилжүүлсэн зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” 14.4. “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа ТӨБЗГ-т саналаа хүргүүлж, цахим дэлгүүрээс худалдан авалт хийж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

5.4.2 Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой

Илрүүлэлт: Нүүдэлчин Монгол наадам, Тууль судлах сурталчлах олон нийтэд түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ, Соёлын ажилтны өдрийн тэмцээний шагнал, материалын үнэ гэх мэт нийт 3.2 сая төгрөгийн зардлын санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангах, бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй, зардлыг санхүүжүүлэхгүй байх. Анхан шатны баримтуудыг иж бүрэн бүрдүүлж ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				
							Үүнээс		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	
Залруулга хийгдээгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримттай холбоотой.	1	3,234.0					1	3,234.0
Нийт	1	3,324.0					1	3,234.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хөрөнгө худалдан авахтай холбоотой асуудал	1	17,890.00					1	17,890.00
Нийт дүн	1	17,890.00					1	17,890.00

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОГДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

43692

73 9066454

Ц.АЗЗАЯА